



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ЭРДЭНЭС АЛТ РЕСУРС ХХК-ИЙН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/66/НА-СТА-ТӨА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор
Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Д.Энхдалай
Утас: 261885 Цахим хаяг: enkhdalaid@audit.gov.mn
Аудитор: М.Лхагвасүрэн
Утас: 261740 Цахим хаяг: lkhagvasuren@audit.gov.mn
Аудитыг гүйцэтгэсэн "Аккурэйт финанс Аудит" ХХК
Захирал: Ж.Оюунбилэг
Утас: 70133743 Цахим хаяг: acc.fin.audit@gmail.com

Улаанбаатар хот
2022 он

Агуулга

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан	5
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	7
3. Аудитын тайлан	8
3.1 Ерөнхий зүйл	8
3.2 Дотоод хяналт	8
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	8
3.4 Материаллаг байдал	8
4. Санхүүгийн тайлангийн тодруулга	9
4.1 Байгууллагын үйл ажиллагаа	9
4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин	9
4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого	10
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	11
5.1 Шилэн дансны мэдээлэл	11
6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	12
7. Дараагийн аудитаар анхаарах асуудал	12
8. Аудитын илрүүлэлт	13
8.1 Төлбөрийн акт	13
9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	14

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2022.03.15 № 071592
танай _____-ны № _____-т

ЭРДЭНЭС АЛТ РЕСУРС
ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Б.АЧИТСАЙХАН ТАНАА

Хараат бус аудиторын тайлан

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Эрдэнэс алт ресурс ХХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Эрдэнэс алт ресурс ХХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудалд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй зүйлсийг тодруулах ба тэдгээрийг аудитын хүрээнд нэгтгэсэн байдлаар авч үзсэн болно

Эрдэнэс Алт ресурс" ХХК нь тайлант онд 2,304.2 сая төгрөгийн үйл ажиллагааны зардал баталсан. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 1,653.1 сая төгрөг зарцуулахаар төлөвлөсөн байна. Гүйцэтгэлээр 0.8 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 2,365.6 сая төгрөгийн зардал гарган, 2,364.8 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Бусад асуудал

Эрдэнэс Алт ресурс" ХХК нь 2019 онд боловсруулсан Үнэт металл цэвэршүүлэх үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэл боловсруулахад ашигласан судалгаануудыг шинэчлэхээр Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамтай хамтран ажиллаж байна. Үүнд:

- Монгол орны хэмжээнд үнэт металлын /алт, мөнгө/ ордуудын нөөцийн судалгаа,

- Шинээр нөөц тогтоогдож бүртгэгдсэн үнэт металлын /алт, мөнгө/ ордуудын мэдээлэл,
- Үнэт металл /алт, мөнгө/ олборлолт, нөөцийн хөдөлгөөн, хэтийн төлөв,
- Үнэт металлын /алт, мөнгө/ ордуудын дагалдах элементүүдийн судалгаа,
- Баяжуулах /алт, мөнгө/ үйлдвэрүүдийн мэдээлэл.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Байгууллагын эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинд 2 зорилтын хүрээнд компанийн тусгай зөвшөөрөл бүхий хайгуулын талбайг эдийн засгийн эргэлтэд оруулах, баялгийн сангийн суурийг бэхжүүлэх ажил хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 80.0 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

“Эрдэнэс Алт ресурс” ХХК нь төслийн хөрөнгө оруулалтын зарим хэсгийг өөрийн хөрөнгөөр шийдвэрлэх, үйлдвэрийг тасралтгүй түүхий эдээр хангах зорилгоор Засгийн газрын 2020 оны 212 тоот тогтоолоор “Ашигт малтмал эрэх хайх” эрх авч уг тогтоолын хэрэгжилтийг хангаж Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл аван олгогдсон хайгуулын талбайг эдийн засгийн эргэлтэд оруулахаар ажиллаж байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР


Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	12,694,781.45	5,132,742.63
1.1.2		-	53,387,100.00
1.1.4	Бусад авлага	8,003,273.09	8,249,923.09
1.1.6	Бараа материал	2,059,017.00	14,377,416.00
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	33,622,234.00	36,554,547.00
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	56,379,305.54	117,701,728.72
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	1,415,695,568.03	1,393,764,601.85
1.2.2	Биет бус хөрөнгө	195,393,389.52	170,131,015.32
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,611,088,957.55	1,563,895,617.17
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,667,468,263.09	1,681,597,345.89
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	29,280,000.00	1,286,416,566.57
2.1.1.2	Цалингийн өглөг	690,722.22	845,045.11
2.1.1.3	Татварын өр	12,900,072.33	23,057,138.46
2.1.1.4	НДШ-ийн өглөг	0.02	49,364,725.68
2.1.1.5	Богино хугацаат зээл	2,697,794,266.20	3,453,167,148.20
2.1.1.6	Хүүгийн өглөг	407,518,855.72	714,338,504.98
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	3,148,183,876.49	5,527,189,129.00
2.1.2	Урт хугацаат өр төлбөр	-	-
2.2	Өр төлбөрийн нийт дүн	3,148,183,876.49	5,527,189,129.00
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч:-төрийн	100,000,000.00	100,000,000.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(1,580,715,613.40)	(3,945,591,783.11)
2.3.11	Эздийн өмчийн дүн	(1,480,715,613.40)	(3,845,591,783.11)
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	1,667,468,263.09	1,681,597,345.89

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)		
2	Борлуулалтын өртөг		
3	Нийт ашиг(алдагдал)		
5	Хүүгийн орлого	1,609,449.35	
8	Бусад орлого	-	848,000.00
10	Ерөнхий ба удирдлагын зардал	587,877,359.84	664,919,419.40
11	Санхүүгийн зардал	269,683,235.13	306,819,649.26
12	Бусад зардал	2,569,030.00	1,393,983,101.05
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)		
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(858,520,175.62)	(2,364,874,169.71)
19	Орлогын татварын зардал	-	
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(858,520,175.62)	(2,364,874,169.71)
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(858,520,175.62)	(2,364,874,169.71)
23	Орлогын нийт дүн	(858,520,175.62)	(2,364,874,169.71)
24	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Д.д	Үзүүлэлт	Өмч	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	100,000,000.00	(722,195,437.78)	(622,195,437.78)
2	Залруулсан үлдэгдэл	100,000,000.00	(722,195,437.78)	(622,195,437.78)
3	Тайлант үеийн цэвэр ашиг		(858,522,175.62)	(858,522,175.62)
4	2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	100,000,000.00	(1,580,717,613.40)	(1,480,717,613.40)
5	Залруулсан үлдэгдэл	100,000,000.00	(1,580,717,613.40)	(1,480,717,613.40)
6	Тайлант үеийн цэвэр ашиг		(2,364,874,169.71)	(2,364,874,169.71)
7	2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	100,000,000.00	(3,945,591,783.11)	(3,845,591,783.11)

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	848,000.00
1.2	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	-	288,000.00
1.3	Бусад мөнгөн орлого		560,000.00
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	580,654,342.50	695,430,860.82
	Ажиллагчдад төлсөн	260,828,576.92	301,909,146.38
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	77,096,093.96	43,000,000.00
	Бараа материал худалдан авахад төлсөн	10,845,855.50	13,763,963.86
	Ашиглалтын зардалд төлсөн	1,431,475.00	1,705,000.00
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	6,020,000.00	21,054,206.00
	Хүүгийн төлбөрт төлсөн	-	1,620,000.00
	Татварын байгууллагад төлсөн	22,648,231.64	21,189,145.14
	Даатгалын төлбөрт төлсөн	2,521,920.00	2,521,920.00
	Бусад мөнгөн зарлага	199,262,189.48	288,667,479.44
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(580,654,342.50)	(694,582,860.82)
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	3,017,153.17	20,000.00
	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	1,407,703.82	20,000.00
	Хүлээн авсан хүүгийн орлого	1,609,449.35	
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	32,267,547.70	14,983,000.00
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	430,000.00	12,285,000.00
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	14,340,490.00	
	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	17,497,057.70	2,698,000.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(29,250,394.53)	(14,963,000)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	363,450,765.00	701,985,822.00
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	363,450,765.00	701,985,822.00
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)		
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	363,450,765.00	701,985,822.00
4	Валютын ханшийн зөрүү	-	
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(246,543,972.03)	(7,560,038.82)
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	259,148,753.48	12,692,781.45
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	12,694,781.45	5,132,742.63

2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2020 оны гүйцэтгэл	2021 оны			
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Нийт орлого	мян.төг	1,609.4	-	848.0	848.0	-
2	Хүүний орлого	мян.төг	1,609.4	-	-	-	-
3	Бусад орлого	мян.төг	-	-	848.0	848.0	-
4	Үйл ажиллагааны зардал	мян.төг	587,879.3	651,092.6	664,914.4	13,821.8	102.1
5	Үүнээс: Удирдлагын зардал	мян.төг	799,330.4	592,505.5	613,850.3	21,344.8	103.6
6	Санхүүгийн зардал	мян.төг	-	-	306,819.6	306,819.6	-
7	Татварын өмнөх ашиг /алдагдал/	мян.төг	(858,522.2)	-	(2,364,874.2)	(2,364,874.2)	-
8	Цэвэр ашиг /алдагдал/	мян.төг	(858,522.2)	-	(2,364,874.2)	(2,364,874.2)	-
9	Төлөх татвар хураамж	мян.төг	58,232.1	58,587.1	51,069.1	(7,518.0)	87.2
10	Тээврийн хэрэгслийн татвар	мян.төг	-	200.0	174.0	(26.0)	87.0
11	Автомашинны даатгал	мян.төг	2,521.9	3,000.0	2,521.9	(478.1)	84.1
12	Газрын төлбөр	мян.төг	16,565.0	2,000.0	-	(2,000.0)	-
13	ЭМНД-ын шимтгэл	мян.төг	39,145.0	53,387.1	48,373.2	(5,013.9)	90.6
14	Нийт ажиллагсдын тоо	хүн	12	12	12	-	100.0
15	Цалингийн сан	мян.төг	308,411.9	395,460.0	377,227.0	(18,232.8)	95.4
16	Хөрөнгө оруулалт	мян.төг	430.0	1,653,068.3	1,393,135.1	(259,933.2)	84.3
17	Тавилга	мян.төг	-	15,200.0	2,300.0	(12,900.0)	15.1
18	Компьютер, тоног төхөөрөмж	мян.төг	430.0	15,800.0	9,985.0	(5,815.0)	63.2
19	Геологи хайгуулын ажлын зардал	мян.төг	-	1,622,068.3	1,381,698.1	(241,218.2)	85.1

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Эрдэнэс алт ресурс ХХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд компанийн дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг 2022 оны 02 дугаар сарын 25-наас 2022 оны 03 дугаар сарын 15-ны хооронд Аккурэйт финанс Аудит ХХК-ийн аудитор Ч.Бат-Эрдэнэ, аудитор Л.Баярмаа аудитор Я.Золзаяа, аудиторын туслах А.Алтанчимэг нар гүйцэтгэж чанарын хяналтыг захирал Ж.Оюунбилэг, чанарын хяналтын менежер Л.Гоёцэцэг нар хэрэгжүүлсэн.

Эрдэнэс алт ресурс ХХК-ийн 2021 оны санхүүгийн тайланг Үндэсний аудитын газарт 2022 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн ЕА-22/14 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Дотоод хяналт

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Эрдэнэс алт ресурс ХХК-ийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 860.1 сая төгрөгөөс 1 хувиар буюу 8.6 сая төгрөгөөр тогтоосон. Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлын суурь болон хувь хэмжээг өөрчлөөгүй бөгөөд 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүн 2,365.6 сая төгрөгөөс 1 хувиар тооцон материаллаг байдлын түвшинг 23.6 сая төгрөгөөр шинэчлэн тогтоосон.

4. Санхүүгийн тайлангийн тодруулга

4.1 Байгууллагын үйл ажиллагаа

Эрдэнэс алт ресурс ХХК нь Монгол Улсын хэмжээнд нийт олборлогдож буй шижир алтыг олон улсын стандартад нийцсэн өндөр технологийн дагуу 99.99 хувийн сорьцтой цэвэр алтан гулдмай үйлдвэрлэх “Алт цэвэршүүлэх үйлдвэр”-ийг (АЦҮ) барьж ашиглалтад оруулах зэрэг үйл ажиллагааг зорилго болгон ажиллаж байна.

Компанийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Компани нь ашгийн төлөө үйл ажиллагаа явуулах бөгөөд хувьцаа эзэмшигчийн хүртэх үр өгөөжийг тогтвортой хангаж, компанийн үнэ цэнийг өсгөхийг эрмэлзэх,
- Компани нь тусгай зөвшөөрөл шаардагдах үйл ажиллагааг хуульд заасны дагуу эрх бүхий байгууллагаас олгосон тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхлэн явуулах,

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд хязгаарлагдмал хариуцлагатай компани гэсэн статустай, 100 хувь төрийн өмчит компани байна.

4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

Эрдэнэс алт ресурс ХХК-ийг Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй “Алт 2” хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, алтны олборлолтыг нэмэгдүүлэх, эрдэнэсийн санд хуримтлал бий болгоход түлхэц үзүүлэх зорилгоор 100 хувь төрийн өмчит “Эрдэнэс Монгол” ХХК-ийн охин компани болон хувьцаа эзэмшигчдийн хурлын 2018 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 06 тоот тогтоолыг үндэслэн байгуулсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд “Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй: ... 5/ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах;...” гэсэн заалттай нийцэж байна.

Компанийн удирдлага болон ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг “Эрдэнэс Монгол” ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар томилж байгаа нь Компанийн тухай хуулийн 75 дүгээр зүйлийн 75.3 Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн тоог компанийн дүрмээр тогтооно, 75.4 Хувьцаат компани болон төрийн өмчийн төлөөлөн удирдах зөвлөл нь ес буюу түүнээс дээш гишүүнтэй байх ба тэдгээрийн гуравны нэгээс доошгүй хувь нь хараат бус гишүүн байна. гэсэн заалттай нийцэж байна.

Эрдэнэс алт ресурс ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллыг 640.0 мянган төгрөгөөр тогтоосон нь ТБОНӨТХ-ийн 21 дүгээр зүйлийн 12 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-ын 3.7-д “...цалин хөлсний хэмжээг тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагааны хүрээ, санхүү, эдийн засгийн байдлыг харгалзан Хувьцаа эзэмшигчдийн хурал тогтооно. Цалин хөлсний хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлснээс ихгүй байна” гэсэн заалттай нийцэж байна.

Монгол Улсын Засгийн газрын “2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.10-т “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт

нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно.” гэж заасан байна. Энэ хөтөлбөрийн Уул уурхай, хүнд үйлдвэрийн дэд хэсэгт “Үнэт металл цэвэршүүлэх үйлдвэрийг барьж байгуулна” гэж тусгасан. Төслийн хөрөнгө оруулалтын зарим хэсгийг өөрийн хөрөнгөөр шийдвэрлэх, үйлдвэрийг тасралтгүй түүхий эдээр хангах зорилгоор Засгийн газрын 2020 оны 6 сарын 01-ний өдрийн 212 тоот тогтоолоор Ашигт малтмал эрэх, хайх эрх авсан. Уг тогтоолын хэрэгжилтийг хангаж хайгуулын талбайг эдийн засгийн эргэлтэд оруулахаар ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Эрдэнэс алт ресурс ХХК-ийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн баталсан заавар, журмын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	12,392.8	5,132.7	(7,560.1)
Дансны авлага	-	53,387.1	53,387.1
Бусад авлага	8,003.3	8,250.0	246.7
Урьдчилгаа	33,622.2	36,554.5	2,932.3
Бараа материал	2,059.0	14,377.4	12,318.4
Үндсэн хөрөнгө	1,611,089.0	1,563,895.6	(47,193.4)
Нийт хөрөнгийн дүн	1,667,466.3	1,681,597.3	14,131.0
Өр төлбөр	3,148,183.9	5,527,189.1	2,379,005.2
Эздийн өмч	(1,480,717.6)	(3,845,591.8)	(2,364,591.8)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,667,466.3	1,681,597.3	14,131.0

Өмнөх оны үзүүлэлтүүдээс дараах дансуудын үлдэгдэлд материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд гарсан байна. Үүнд:

- Бэлэн мөнгөний үлдэгдэл 7.6 сая төгрөгөөр буурсан нь батлагдсан төлөвлөгөөнөөс үйл ажиллагааны санхүүжилтийг 1,220.0 сая төгрөгөөр дутуу олгосон.

Тайлант онд дансны авлага 53.4 сая төгрөгөөр нэмэгдсэн нь толгой компаниас авах авлага санхүүжилтийн авлага байна.

Урьдчилгаа дансны үлдэгдэл 36.6 сая төгрөг болж өссөн нь тайлант онд байгууллагын вебсайт хийлгэх ажлын төлбөрт 3.0 сая төгрөгийн урьдчилгаа шилжүүлсэн байна. Урьдчилгаа дансанд алт цэвэршүүлэх үйлдвэр бариулахтай холбоотой гэрээт төслийн ажлын зардлыг хуримтлуулан бүртгэсэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 14.4 сая төгрөг болж 12.3 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд 21.8 сая төгрөгийн хангамжийн материал, ажлын хувцас, сэлбэг хэрэгсэл худалдан авч 9.5 сая төгрөгийн материал зарцуулагдсанаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 47.2 сая төгрөгөөр буурсан нь 10.2 сая төгрөгийн хөрөнгийг ангилал хооронд залруулж, 59.4 сая төгрөгийн элэгдэл байгуулсантай холбоотой байна. Тайлант онд шинээр 12.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан байна.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэл 5,527.2 сая төгрөг болж 2,379.0 сая төгрөгөөр өссөн нь тайлант оны толгой компаниас авсан санхүүжилтийн өглөг 755.4 сая, зээлийн хүүгийн өглөг 306.8 сая, геологи хайгуулын ажил хийлгэсэн төлбөр 1,257.2 сая, цалингийн өглөг 0.2 сая, НДШ-ийн өглөг 49.4 сая, ХХОАТ-ын өглөг 10.2 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэнтэй холбоотой байна.

Санхүүгийн тайланд зардал өртгийн талаарх мэдээллийг бэлтгэх зорилгын дагуу үйл ажиллагааны зардал, санхүүгийн зардал, бусад зардал гэж ангилсан байна. Зардал өмнөх онтой харьцуулахад бусад зардал 1,391.3 сая төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант онд хайгуул, судалгаа, нөхөн сэргээлтийн ажлууд хийгдсэнээс шалтгаалжээ.

4.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Эрдэнэс алт ресурс ХХК нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 21/04 дугаар тогтоолоор Эрдэнэс алт ресурс ХХК-ийн 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт зардлыг 2,304.2 сая төгрөг байхаар тогтоосон байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 1,653.1 сая төгрөгийг төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр 0.8 сая төгрөгийн бусад орлого бүрдүүлж, 2,365.7 сая төгрөгийн зардал гарган, 2,364.8 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна. Энэ нь үндсэн үйл ажиллагаа явуулаагүй, орлого бүрдүүлж ажиллаагүй, Эрдэнэс монгол ХХК-аас авсан зээлийн хүүгийн зардал өссөн нь гол нөлөө үзүүлсэн байна.

5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Аудитын явцад шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгаж үзэхэд тайлант хугацаанд оруулбал зохих 164 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 105 мэдээллийг хугацаандаа оруулсан, 59 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан зөрчилтэй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансанд мэдээллийг хугацаанд нь иж бүрэн байршуулах, шилэн дансны тухай хуулийг мөрдөж ажиллах, хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлэх.

5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Монгол Улсын ерөнхий аудиторын 2021 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн А/111 дүгээр тушаалаар баталсан Ерөнхий чиглэл, аргачилсан зөвлөмжийн дагуу гаргасан судалгааг шалгагдагч байгууллагаар гаргуулан хянаж аудитдаа ашигласан болно.

Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг шалган үзэхэд дараах байдалтай байна.

Албан конторын тавилга, компьютер нотебүүк зэрэг үндсэн хөрөнгө 12.4 сая, албан хаагчдад байгууллагын логотой ажлын хантааз хийлгэхэд 1.0 сая, хүлээн авалт, ажил хэргийн уулзалт, бэлэг дурсгалын үнэнд 3.7 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Энэ нь Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг шалгахад тогтоолын 1.3-д заасан "цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх", 1.4-д заасан "авто машин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, ... худалдан авалтыг зохион байгуулахгүй байх" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Засгийн газраас авч хэрэгжүүлж байгаа “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээ”-г хэрэгжүүлж ажиллах төсвийг үр ашигтай, хэмнэлттэй зарцуулж, зориулалт бус зардал гаргахгүй байх, албан шаардлага хүргүүлэх.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомж болон Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын холбогдох заалтуудтай тус тус нийцээгүй байна гэж дүгнэлээ.

6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1.1 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 1 албан шаардлага хүргүүлж, 10.2 сая төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өгснөөс акт, зөвлөмж 100.0 хувь, албан шаардлага 80.0 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 2. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		Хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Төлбөрийн акт	1	1,050.0	1	1,050.0			100.0
Албан шаардлага	1	-		-	1		80.0
Зөвлөмж	3	10,290.9	3	10,290.9			100.0
Нийт дүн	5	11,340.0	4	11,340.0	1		93.3

Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаанд нь иж бүрэн байршуулаагүй, Шилэн дансны тухай хууль тогтоомжийн хэрэгжүүлж ажиллах өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжилт хангалтгүй байгааг үндэслэн холбогдох ажилтанд хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байгууллага дээр ажиллаж нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэн, бараа материалын биет тооллого хийх, хэрэгжүүлж байгаа төсөл арга хэмжээний гүйцэтгэлийг дараагийн аудитаар шалгахаар шийдвэрлэсэн.

8. Аудитын илрүүлэлт

Аудитаар илэрсэн 3.7 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоосон.

Залруулагдаагүй 3.7 сая төгрөгийн алдаа зөрчил нь тогтоосон 23.6 сая төгрөгийн ерөнхий материаллаг байдлын түвшнээс 19.9 сая төгрөгөөр бага байгаа тул “Зөрчилгүй” дүгнэлт өглөө.

8.1 Төлбөрийн акт

Тус байгууллага нь Ланд 200 маркын 52-70 УБҮ улсын дугаартай 1 машинтай боловч Аюуд пропорти ХХК-тай хийсэн түрээсийн гэрээгээр 2 машины зогсоолын түрээсийн төлбөрт 3,700.0 мянган төгрөгийг илүү төлсөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 6.4.2-т “төрийн чиг үүрэгт хамаарахгүй хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх”, 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоох,

Дээрх албан шаардлага, төлбөрийн актын биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс									
							Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн асуудлаар																
1	Эрдэнэс Алт ресурс ХХК	АХГ-2022/66/НА-СТА-ТӨА	Ланд 200 маркын 52-70 УБУ улсын дугаартай 1 машинтай түрээсийн гэрээгээр 2 машины зогсоол түрээсэлж 3,700.0 мянган төгрөгийг илүү төлсөн байна.	Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй зарцуулж, зориулалт бус зардал гаргахгүй байх, Төлбөрийн акт тогтоох,	1	3,700.0			1	3,700.0						
ДҮН					1	20,783.5			1	3,700.0						-
Санхүүгийн тайлангийн асуудлаар шалгасан нийцлийн асуудал																
1	Эрдэнэс Алт ресурс ХХК	АХГ-2022/66/НА-СТА-ТӨА	Өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй 164 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 105 мэдээллийг бүрэн байршуулж, 59 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна	Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж мэдээллийг ил тод, цаг хугацаанд нь бүрэн байршуулж Байх, Хариуцлага тооцох, албан шаардлага өгөх	1	-							1	-		
2	Эрдэнэс Алт ресурс ХХК	АХГ-2022/66/НА-СТА-ТӨА	Үндсэн хөрөнгө 12,385.0 мянга, ажлын хантааз хийлгэхэд 952.0 мянга, хүлээн авалт, ажил хэргийн уулзалт, бэлэг дурсгалын үнэнд 3,746.5 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.	Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй зарцуулж, зориулалт бус зардал гаргахгүй байх, албан шаардлага өгөх	1	17,083.5					1	17,083.5				
ДҮН					2	-					1	17,083.5	1	-		
НИЙТ ДҮН					3	20,783.5			1	3,700.0	1	17,083.5	1	-		-



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2022 оны 03 дугаар сарын 15 № 114/Н0150053
АХГ-2022/66/НА-СТА-ТӨА
Төлбөр барагдуулах тухай

Улаанбаатар хот

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу Эрдэнэс Алт ресурс ХХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус байгууллагад Ланд 200 маркийн 52-70 УБУ улсын дугаартай 1 машин бүртгэлтэй байна. Аюуд пропорти ХХК-тай хийсэн түрээсийн гэрээгээр 2 машины зогсоол түрээсэлж, 3,700,000.00 төгрөг илүү төлсөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 6.4.2 "төрийн чиг үүрэгт хамаарахгүй хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх", 16.5.5 "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.


Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3-т заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Илүү төлсөн зогсоолын түрээсийн төлбөр болох 3,700,000.00 /гурван сая долоон зуун мянга/ төгрөгийг Үндэсний аудитын газрын Төрийн сан банкин дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2021 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Эрдэнэс Алт ресурс ХХК-ийн захирал Б.Ачитсайхан, нягтлан бодогч Б.Батсүх нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АККУРЭЙТ ФИНАНС АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Д.ЭНХДАЛАЙ
Ж.ОЮУНБИЛЭГ



Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig_Kherig\Akt\2022\0315 Auditin 4 Gazar-53.Docx

0001090278



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 498/А0150053
АХГ-2022/66/НА-СТА-ТӨА

Улаанбаатар хот

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу Эрдэнэс алт ресурс ХХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:


Өмнөх оны алдаа, зөрчлийг дахин давтан гаргаж шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг биелүүлээгүй нийт 164 мэдээлэл шилэн дансны цахим хуудсанд оруулахаас 59 мэдээлэл хугацаа хоцроож байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.3 “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3 “Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журмын 4.2.2 “Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд “Сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлнэ” гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Зөрчил гаргасан Нягтлан бодогч Б.Батсүхэд хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулж, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Эрдэнэс алт ресурс ХХК-ийн гүйцэтгэх захирал Б.Ачитсайханд даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР Д.ЭНХДАЛАЙ
АККУРЭЙТ ФИНАНС АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ Ж.ОЮУНБИЛЭГ



Монгол Улс Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-764230

\\10.10.10.20\Bichig_Kherag\Alban Shaardlaga\2022\0315 Auditin 2 Газар-192.Docx

0001081352



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 499/А/0150053

Улаанбаатар хот

АХГ-2022/66/НА-СТА-ТӨА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу Эрдэнэс алт ресурс ХХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Үндсэн хөрөнгө худалдан авахад 12,385,000.00 төгрөг, ажлын хантааз хийлгэхэд 952,000.00 төгрөг, хүлээн авалт, ажил хэргийн уулзалт, бэлэг дурсгалын үнэнд 3,746,500.00 төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Энэ нь Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.6 заасан "Засгийн газрын шийдвэр гарснаас бусад баяр ёслол, тэмдэглэлт ой, урлагийн наадам, спортын уралдаан тэмцээн, салбарын өдөр, аялал зугаалга зэргийг зохион байгуулахгүй байх", 1.3 заасан "цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх", 1.4-д заасан "авто машин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, ... худалдан авалтыг зохион байгуулахгүй байх" гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө." Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй зарцуулж, зориулалт бус зардал гаргахгүй байх, биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрдэнэс алт ресурс ХХК-ийн гүйцэтгэх захирал Б.Ачитсайхан, нягтлан бодогч Б.Батсүх нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АККУРАЙТ ФИНАНС АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
Д.ЭНХДАЛАЙ
Ж.ОЮУНБИЛЭГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig_Kherig\Yawsan_Bichig\2022\0315_Auditin_2_Gazar-191.Docx

0001081350

